



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/583

Арвайхээр

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах  
тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.2.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2.4.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангай түншлэл-2019” үзэсгэлэн худалдааг 2019 оны 09 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Өвөрхангай түншлэл-2019” үзэсгэлэн худалдааг сайтар зохион байгуулж, гарсан үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (И.Доржсүрэн)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5.000.000 (таван сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД


011101068

Аймгийн Засаг даргын 2019 оны 09  
дугаар сарын 16-ны өдрийн 1158 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: -И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)  
Нарийн бичгийн дарга: -Б.Ууганбаяр (Өвөрханга аймаг дахь Худалдаа аж  
үйлдвэрийн танхимын дарга)
- Гишүүд: -С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө  
аж ахуйн газрын дарга)  
-С.Дуламсүрэн-(аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн  
хяналтын газрын дарга)  
-С.Ундрах (аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн  
үйлчилгээний газрын дарга)  
-Г.Мөнхтөр- (аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт,  
хэмжил зүйн хэлтсийн дарга)  
-Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)  
-О.Пүрэвдорж (Арвайхээр сумын Засаг дарга)  
-Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын Албаны дарга)  
-Д.Батцэнгэл (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын мэргэжилтэн)  
-Д.Бямбадулам (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын мэргэжилтэн)

-oOo-


  
 Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дугаар сарын 18 ны өдрийн А/С дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

| №                   | Зардлын нэр   | хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  |
|---------------------|---|-------------|----------------|-----------|
| <b>Шангал</b>       |   |             |                |           |
| 1                   | Өвөрхангай түншлэл гранпри                          | 1           | 500000         | 500.000   |
| 2                   | Шилдэг оролцогч сум                                 | 1           | 300000         | 300.000   |
| 3                   | Шилдэг гар урлалын бүтээгдэхүүн                     | 1           | 300000         | 300.000   |
| 4                   | Хөдөлмөр хөнгөвчилсэн хөдөө аж ахуйн шинэлэг бүтээл | 1           | 300000         | 300.000   |
| 5                   | Бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн                 | 1           | 300000         | 300.000   |
| 6                   | Хөнгөн үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүн               | 1           | 300000         | 300.000   |
| 7                   | Хүнсний салбарын шилдэг бүтээгдэхүүн                | 1           | 300000         | 300.000   |
| 8                   | Шилдэг цагаан идээ                                  | олон төрөлт | 500000         | 500.000   |
| 9                   | Ургацын баярын шагнал                               | олон төрөлт | 500000         | 500.000   |
| 10                  | Өргөмжлөл   | 9           | 30000          | 270.000   |
| 11                  | Цом   | 1           | 80000          | 80.000    |
| 12                  | Бүтээгдэхүүн сурталчилах гэрэл зургийн уралдаан     | 1           | 466000         | 466.000   |
|                     | Дүн   |             |                | 4.116.000 |
| <b>Бусад зардал</b> |   |             |                |           |
| 10                  | Хулдаасан хэвлэл                                    | 2           | 192000         | 384.000   |
| 11                  | Түншлэлийн тайз засах                               | 1           | 500000         | 500.000   |
|                     | Дүн   |             |                | 884.000   |
|                     | Нийт дүн  |             |                | 5000.000  |